

“МОН-НАБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

“МОН-НАБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2023 оны 08 дүгээр сарын 17-ны өдөр Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг 6-р хороо Жуулчны гудамж -19, Хишиг төв 7 давхар 701 тоотод болов. Хурал 14.00 цагаас эхлэж ТУЗ –н дарга Р.Зоригт даргалан явуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд хувьцаа эзэмшигч:

- Т. Бадамжунай / 62400 ширхэг хувьцаа эзэмшигч/
 - Р.Зоригт / 37497 ширхэг хувьцаа эзэмшигч/
- нар тус тус хүрэлцэн ирсэн

ТУЗ- н гишүүд :

- Ш.Оюун-Эрдэнэ
- Г.Төгөлдөр
- Д.Болорцэцэг
- Л.Амарсайхан
- Р.Алтанцэцэг

нар хүрэлцэн ирж ирц 81.3 % байна гэж хурал зохион байгуулах комиссийн гишүүн Г.Төгөлдөр танилцуулав.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцсэн болно. Үүнд:

- Компанийн 2022 оны үйл ажиллагааны , санхүүгийн байдалд ТУЗ-н өгсөн дүгнэлт ;
- ТУЗ-н ажлын тайланг хэлэлцэж батлах;
- Компанийн үйл ажиллагааны цаашдын зорилтыг хэлэлцэж батлах;

Хувьцаа эзэмшигчдийн хуралд “Компанийн 2022 оны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд ТУЗ-ийн хийсэн дүгнэлт” - ийг ТУЗ-ийн дарга Р.Зоригт танилцуулж, дараах нэмэлт тайлбарыг хийв.

Хувьцаа эзэмшигчид 2023 онд ээлжит хурлаа хийсэн. Гэвч тодорхой шалтгааны улмаас дахин ээлжит бус хурал зарлан хуралдуулж байна.Компанийн өдөр тутмын асуудлыг шийдвэрлэж байна.Ээлжит хурлаас хойш өөрийн эзэмшлийн дулааны шугамаа засварлах ажил хийж байна .Хагас жилийн санхүүгийн болон татварын тайлан тушаагдсан.

Хэлэлцсэн асуудалтай холбогдуулаан санал шүүмжлэл дараах байдлаар өрнөв. Үүнд:

Р.Зоригт: Компанийн үйл ажиллагааг бол барилгын чиглэлийг нь хадгалаад явна гэсэн бодолтой байгаа. Хувьцаат компанийн хувьд өөр чиглэлийн ажил хийнэ гэдэг хэцүү. Хөрөнгө оруулалтын ажлаа ийшээ чиглүүлнэ гэсэн бодолтой.

Ш.Оюун-Эрдэнэ: Компанийн хувьцаа эзэмшигчид хуралдаа ирэхгүй өнгөрсөн хойно нь хороогоор явж байна.Бид журмын дагуу хурлын зар хүргэж байгаа.Хувь хүн хариуцлага хүлээх хэрэгтэй .

Р.Алтанцэцэг: Санхүүгийн тайлан балансаа “Ай Жэй Эй Эйч- АУДИТ”ХХК –аар аудитын гэрээ хийж дүгнэлт гаргуулсан хойшид хамтран ажиллах болно.Энэ

байгууллагын ажил төрөл ямар байдлаар яаж ашигтай ажиллуулбал зүгээр талаар оновчтой санал хэлэх хүн байна уу.

Д.Болорцэцэг: Хувьцаа эзэмшигчид хуралдаа муу оролцож байна. Хуралд ирж байгаа хүмүүс нь ноогдол ашиг тараах тухай их асуух юм. Үндсэн үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрөл энээ тэрээ юм шаарддаг юм бол өөр жижиг ажил хийвэл болохгүй юу. Ажиллах боловсон хүчин хэрэгтэй, сайн ажилчид хэрэгтэй. Зээл авах талаар хөөцөлдсөн юм байна уу.

Р.Алтанцэцэг: Урд хийсэн хурал дээр би хэлж байсан. Зээлийн шаардлагад манай байгууллага нийцэхгүй байгаа. ТУЗ-н хувьд гишүүдээ ажлуулмаар санал бодлыг сонсож тусламж дэмжлэг авмаар байна. Р.Зоригт ТУЗ-н даргын хувьд ч хувьцаа эзэмшигчийн хувьд ч идэвхи гарган янз бүрийн юмны өмнө л байх юм.

Ш.Оюун-Эрдэнэ: Бид олон нийтийн сонин хэвлэл, брокер пүүс, утсаар хүртэл яриад байхад хуралд ирэх нь цөөхөн байна.

Хувьцаа эзэмшигчид хурлын зар, бичиг баримт хуралд хэлэлцэх асуудал, байгууллагын өнөөгийн байдлын талаар мэдээллийг олон сувгаар авах боломжтой.

Л.Амарсайхан: Цаашид ямар ажил төлөвлөж байна вэ? Инженер, техникийн ажилтнууд байна уу?

Р.Алтанцэцэг: Бид энэ компанийн ажлыг өөднө татаж цаашид юу хийж яаж ажиллах талаар сайн ярилцмаар байна. ТУЗ-н хурал хийхээр ирчээл бусад үед оролцоо муу байна.

Т.Бадамжунай: Би хурлын хэлэлцэж байгаа асуудалтай санал нэг байна. Цаашдаа сайн ажиллах хэрэгтэй шүү. Мэргэжлийн боловсон хүчин хэрэгтэй байна даа. Хурлаас гарах шийдвэрийг дэмжинээ.

Ш.Оюун-Эрдэнэ: Энэ хуралд хараат бус гишүүд оролцож байгаа санал хүсэлт хэлэх байхаа

Д.Болорцэцэг: Хөрөнгө оруулалт татах хэрэгтэй юм шиг санагдах юм. ТУЗ-н гишүүд идэвхи санаачлага муутай байна.

Миний хувьд жил бүр хуралд ирдэг. Хувьцаа эзэмшигчид шүүмжлээд байхаас биш бид ямар үүрэгтэй байх вэ яавал энэ байгууллагыг сайн болгох тухай олигтой санал хэлдэггүй. Зарим нэг хүмүүс нь бүр доромжлоод хурлаа хаяад гардаг. Сайн менежмент хэрэгтэй гэж бодож байна. Ямар менежментээр яаж ажиллах вэ гэдгийг ярилцах хэрэгтэй.

Г.Төгөлдөр: Бид энэ компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцох боломж байдаггүй өөр өөрийн ажлаа хийгээл явж байдаг. Хувьцаа эзэмшигчид ноогдол ашиг тараах уу гэж их асуудаг байгууллагаа яаж ажилтай байлгах уу гэж боддоггүй. Туслаад дэмжээд ажиллах хүн алга. Зарим хувьцаа эзэмшигчид боломжтой хамтраад ажил хийвэл болох юм шиг санагддаг.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Компанийн цаашдын зорилтыг хэлэлцэв. Компанийн цаашдын зорилтыг хэлэлцэн батлахтай холбогдуулан Р.Зоригт өөрийн саналаа хэлэв:

- 2023 онд Санхүүгийн байдлаа сайжруулах өр төлбөрийн асуудлаа шийдвэрлэх;


- Төслийн ажлын гэрээ санхүүжилтыг баталгаажуулах;
- Гадна болон дотор дулааны шугамын засварын ажлыг бүрэн дуусгах;

Компанийн тухай хуулийн 77р зүйлийн 77.2 ,Компанийн дүрмийн 10.6 -д заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-н гишүүдийн бүрэн эрхийн хугацааг дараагийн ээлжит хурал хүртэл сунгаж дэд хороодууд хуучин бүрэлдхүүнээрээ ажиллахаар хувьцаа эзэмшигчдийн хурлаар санал нэгтэй батлав.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцсэн асуудлуудын талаар тогтоол гаргахаар тогтож, тогтоолын төсөл бүрийг хэлэлцэж, тэдгээрийг санал нэгтэйгээр батлав.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 16.00 цагт дуусав.

ХУРЛЫН ДАРГА



Р.Зоригт